



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 24 өдөр

Дугаар 658

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин
зохион байгуулах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолын 4.2, 4.4, 269 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон нийт 35,939,874.55 (гучин таван сая есөн зуун гучин есөн мянга найман зуун далан дөрвөн төгрөг тавин таван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 33,074,704.25 (гучин гурван сая далан дөрвөн мянга долоон зуун дөрвөн төгрөг хорин таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 1 автомашин нь хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, “Дарханы дулааны цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



0001200

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 1 дугаар сарын 3 ны өдрийн
65 дүгээр тогтоолын хавсралт

"ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРНЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

№	Автомашинны марк, улсын дугаар, арал	Гүйлт	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Тоо хэмжээ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	2019 оны 234 дүгээр тогтоолоор	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ
1	Автобус, Хьюндай-520, 17-40 ДАА, KMJSA18HPT400129	577,648.00	1995/1996	1	35,939,874.55	33,074,704.25	2,865,170.30	5,000,000.00	3,000,000.00
НИЙТ ДҮН									
					35,939,874.55	33,074,704.25	2,865,170.30	5,000,000.00	3,000,000.00
					(гучин таван сая есөн зуун гучин есөн мянга найман зуун далан дөрвөн төгрөг тавин таван мөнгө)	(гучин гурван сая далан дөрвөн мянга долоон зуун дөрвөн төгрөг хорин таван мянга)	(хоёр сая найман зуун жаран таван мянга нэг зуун далан мянга гучин мөнгө)	(таван сая)	(гурван сая)